



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/415

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу "Буянсацрах" ХХК-ий эзэмшлийн Хэрлэн сумын 5 дугаар баг, "Мах экспорт" ХХК-ий зүүн хойд талд байрлах, үйлдвэрлэлийн зориулалттай 3780 м² газрыг "Чингис органик хүнс" ХХК-д 23 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. "Чингис органик хүнс" ХХК-ий эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Чингис органик хүнс" ХХК /Ж.Ариунзул/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2011 оны 47 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА